

РАДИО СУРВАЛЖЛАГЫН УРАН ЧАДВАРЫН АСУУДАЛД

Д.Батжаргал*

* Хэвлэлийн хүрээлэнгийн сэтгүүл зүйн багш, докторант

Түлхүүр үг: сурвалжлага, сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, дүрслэлийн хэлбэрүүд, зүйрлэл.

• Далан давхарт хотын борчууд амьдарч байна. Тэд "Хүчит шонхор" захын хоосон яс бараадан хүмүүсийн булшин дээр гэрээ барьчихаад хүүхэд нь сургуульгүй, өөрсдөө бүртгэлгүй сууж байна.

• Энд тэнд гялгар хальсан хүүдий бөмбөгөнөж, нохой гахай цаас яс хөглөрүүлэн гүйлдэнэ.

• Сурвалжлагын генийг залхуу хүмүүс устгаж байна

Сурвалжлага гэдэг нь уламжлах мэдээлэх гэсэн үгнээс гаралтай сэтгүүл зүйн дайчин шуурхай төрөл. Нийтэд хамаатай үйл явдал, үзэгдэлд зохиогч өөрөө оролцсоны үндсэнд нүдэнд харагдаж, сэтгэлд буутал дүрслэн үзүүлдэг хамгийн сонирхолтой, хөгжил, хөдөлгөөнтэй мэдээллийн төрөл. Гэтэл сэтгүүл зүйн энэ сайхан төрөл "улаан ном"-д орохоор ховорджээ.

Монголын сэтгүүл зүйд дэлхийн ховордсон амьтны нэг мазаалайнаас ховор болсон байж магадгүй. Сонин хэвлэл, радио телевиз онлайн гэсэн хэрэгсэл бүрт ховорджээ. Харин мэр сэр гэрэл зургийн сурвалжлага үзэгдэх юм. Радио сэтгүүл зүйн хувьд хамгийн чухал төрөл. Яагаад гэвэл сонсогчдыг тэр орчинд "аваачдаг" дүрслэл бий болгодгоороо илүү чухал.

Хэвлэлийн хүрээлэнгийн өнгөрсөн жилийн судалгаагаар богино долгионы радио станц, Улаанбаатар, МҮОНР зэрэг хорь шахам "агаарын сонин"-ы хамгийн их сонсогчтой 142 нэвтрүүлгийг жагсаахад нэг ч сурвалжлага алга. Ерөөсөө сурвалжлагын цаг гэж байхгүй болчихож. Монголчууд радио үүсч байх гучаад оны эхээр түүнийг "цаасгүй сонин", "агаарын сонин" гэж мэдээлэл түгээдэг хэрэгсэлтэйгээ зүйрлэн нэрлэж байлаа. Тэр утгаар нь аваад үзвэл нэг ч гэрэл зураггүй хавтгай төмөр шиг сонин очиж байна гэсэн үг. Учир нь радио сэтгүүлч үзэгдэл үйл явдлын орчинд сонсогчдыг аваачих учиртай "амьд"

төрөл билээ. Микрофоноор гэрэл зургийн дуран, ТВ камер шиг дүрслэн үзүүлэх ёстой гэж ярилцдаг.

Энэ оны дөрөвдүгээр сард Монголын радиогийн "Хурд" агентлагт сургалт хийлээ. Мэдээллийн олон хөтөлбөрийг сонслоо. Дүрсэлсэн сурвалжлага байдаггүй. Арваад удаагийн хөтөлбөрийг сонсоход сэтгүүлч Шаравын Батжаргалын бэлтгэсэн ганцхан сурвалжлага орж байна.

Орон даяар нэвтрүүлгээ цацдаг "Хурд" агентлаг мэдээллийн албандаа хорь гаруй сэтгүүлчтэй тэднээс судалгаа авахад доорхи хариулт өгч байна.

□ "Танд мэдээллийн хөтөлбөрийг өөрчлөх ямар санал байна?" гэсэн асуултад:

- Цагт баригдалгүй шуурхай хүргэе (заавал 10 минутаар зааглахгүй)

- Эфирээс редактор хөтөлье

- Амьд дүрсэлсэн сурвалжлага хүргэе

- Шууд утсаар холбогдье

- Өөрсдөө хөтөлье гэж олонтаа хариулжээ.

□ Мэдээллийн хөтөлбөрийг шинэчлэх, шууд эфирт орж ажиллахад саад болж зүйлийн талаар удирдлагын зүгээс гэж 3, бүтцийн хуучин загвар гэж 5, техникийн боломж гэж 10, өөрийн чадвар дутагдаж байна гэж 3 сэтгүүлч тус тус бичжээ. Харин мэдээгээ эфирээс шууд дамжуулах сонирхолтой нь олон байна.

□ Санал асуулгад оролцсон сэтгүүлчдээс "Мэдээллийн хөтөлбөр бүртээ

дүрсэлсэн сурвалжлага оруулж байя гэвэл санал нийлэх үү?" гэсэн асуултад бүгд "Нийлж байна" гэж бичжээ.

Залуусын энэ сайхан хүсэл эрмэлзлийг бид дэмжих ёстой. Сэтгүүл зүйн багш нар бид хичээлийн хөтөлбөртөө ажиглалт, дүрслэл, сурвалжлагын дадлага их оруулж, оюутнуудаар байнга хийлгэх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол үг оноод хэлчихдэг залуус ховорджээ. Олон оюутнаар дасгал сургуулилт хийлгэхэд даанч чамлалттай. Яагаад гэвэл ерөнхий боловсролын сургуульд хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхгүй байна. Багш нар эцэг эхчүүд хүүхдийг яриулж, ном уншуулж сургахгүй, болсон болоогүй гадаад хэлний курсээр монгол хүүхдээ хэл сэтгэхүйн хувьд танигдахгүй болтол эрлийзжүүлж байна. Англи ч биш, монгол ч биш, орос ч биш, хятад ч биш хүүхэд залуус олон болжээ.

Монгол хэлийг гадаад хэлний өгүүлбэрийн бүтцээр ярьж байгаа хүүхэд яаж дүрслэх юм бэ?. "Би очлоо, одоо чам дээр" гэж утсаар ярьж байгаа оюутан та бидний хажууд зогсож байна. Эх хэл гэдэг эмзэг юм. Амархан эвдэрдэг хэврэг үзэгдэл.

Төрийн соёрхолт зохиолч Дарамын Батбаярын "Алтан хараацай" өгүүллэгт: "...Тойрог татах мэт дугуйран нисч, ертөнцийн тигийг агаарт зурж тоглодог юм. Заримдаа олуулаа... Заримдаа хосоороо... Заримдаа ганцаараа... Том, жижиг янз бүрийн тигнүүд... Хараацай нисэхийг харах бүр ухаан санаа ариусах шиг болж, улам улам баясан ширтэхэд

хүргэдэг юм. Дүүлэн нисч тэнгэрт гарсан бойноо тал, талаасаа нийлэн олуулаа болж, хөхрөлдөн гүйлдэх хүүхдүүд мэт тоглон наадна. Инээд алдан нисч байгаа мэт харагдах нь гэгээн, ариун амьтан бүхэн адилхан байх юм даа хэмээн өөрийн эрхгүй бодогдуулна. Тэгснээ гэнэт цацсан будаа шиг тал, тал тийшээ бутран, ганц хоёроороо болон ниснэ...¹ гэж дүрсэлжээ. Ийм дүрслэл хэрэгтэй байна.

Энэ оны гуравдугаар сард “Дэлхийн зөнгийн” орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар Өвөрхангай аймгийн эмч нарын дунд радио сэтгүүл зүйн сургалт хийлээ. Дөрвөн бүлэг аштайхан сурвалжлага хийлээ. “...Хогон дотор хотхон байна уу, эсвэл хотхон доторхи хог

байна уу гэдгийг ялгахын аргагүй. Энд тэнд гялгар хальсан хүүдий бөмбөгөнөж, нохой гахай цаас яс хөглөрүүлэн гүйлдэнэ...” гэж нэг хэсэг нь оновчтой дүрсэлж байхад “Чингэлэг ажлын байр мөн үү” гэсэн сурвалжлага бэлтгэсэн эмч нар “Өвөлдөө нар тусахгүй жавар хаахгүй болохоор хөргөгч шиг хүйтэн, зундаа салхи орохгүй битүү болохоор пийшин шиг халуун энэ төмөр чингэлэг нэг онгойлгочихоор хааж болдоггүй ажлын байр юм. Энд зогсож худалдаа

хийж байгаа хүмүүсийн ихэнх нь эмэгтэйчүүд. Тэд бөөр, шээсний замын өвчтэй болж байна” гэж ярьж байна.

Ийм үгийг эмч нар хэлж байхад сэтгүүлчид мэдээллийн хөтөлбөрөө хуурай хөндий, албаны мэдээ зонхилсон, амьдралын содон сонин үйл явдал багатай бэлтгэж байна. Иргэний сэтгүүл зүйн бүтээлүүд илт дутагдах юм. ОНРТ-ээс хэдхэн алхмын зайтай Далан

давхарт хотын борчууд амьдарч байна. Тэд “Хүчит шонхор” захын хоосон яс бараадан хүмүүсийн булшин дээр гэрээ барьчихаад хүүхэд нь сургуульгүй, өөрсдөө бүртгэлгүй сууж байна. Эндээс амьд сурвалжлага хийж болно. Олон түмний амьдрал ямар байгааг харах нүд байхгүй байна гэхэд

«
Сурвалжлага гэдэг нь уламжлах мэдээлэх гэсэн үгнээс гаралтай сэтгүүл зүйн дайчин шуурхай төрөл. Нийтэд хамаатай үйл явдал, үзэгдэлд зохиогч өөрөө оролцсоны үндсэнд нүдэнд харагдаж, сэтгэлд буутал дүрслэн үзүүлдэг хамгийн сонирхолтой, хөгжил, хөдөлгөөнтэй мэдээллийн төрөл. Гэтэл сэтгүүл зүйн энэ сайхан төрөл “улаан ном”-д орохоор ховорджээ.

»
харамсмаар.

Доктор Л.Амарзаяа “Радио нэвтрүүлэг дэх дүрслэлийн нөлөө” өгүүлэлдээ үгээр урлах дүрслэл, дуу хөгжмөөр дүрслэх, чимээ шуугианаар дүрслэх гэж радиогийн амин судас болсон дүрслэлийн элементүүдийг зөв зүйтэй тайлбарлажээ². Харин би энд дүрслэх яриа гэсэн нэг элемент нэммээр байна.

Хүмүүсийн харах боломжгүй үйл явдлыг яруу тод томруун дүрслэн сэтгэхэд тус дөхөм болох тийм дүр

зургийг бий болгож байгаа хэсгийг "дүрслэх яриа" гэж хэлдэг. Хэл найруулгаар дамжуулан дүрслэх дүр зургийг гаргах янз бүрийн арга бий. Түүний нэг жишээг энд дурдъя. Гурван хүн нэг өрөөнд хамт байлаа гэхэд нэг нь нөгөөдөө "Чи өнөөдөр сайхан харагдаж байна" гэж хэлэхэд гурав дахь хүн энэ нь чухам ямар санааг агуулж байгааг тэр даруй тусгаж авна. Ингэж хэлэх болсны учир нь нөгөө хүн үсээ шинэ маягаар зассан, эсвэл шинэ хувцас өмссөн, аль эсвэл арай залуу, илүү жавхаатай харагдаж байна гэдгийг өөрийн нүдээр харж мэднэ. Харин та өөр өрөөнд байгаад үүнийг хэлсэн хүнийг харах боломжгүй. Хэлсэн үг чухам ямар утгатай байсныг яаж мэдэх вэ? Радио сонсож буй хүн яг ийм байдалтай байна. Болж буй үйл явдлыг дүрслэхийн тулд тодорхой дүрс, өнгө, зүс болон ингэж сэтгэхэд нь тус болох бусад зүйлийг тэд мэдэх хэрэгтэй байдаг юм. Тийм учир "Чи өнөөдөр сайхан харагдаж байна" гэж хэлэхийн оронд "Чиний нүд өнөөдөр цогтой байна", эсвэл "Улаан өнгө чамд зохих юм" гэж хэлбэл илүү зохимжтой.

Зүйрлэл буюу адилтгах үг бол дүрслэн сэтгэх ярианы бас нэг арга, нэгэн зүйлийн харьцуулалт юм. Тухайлбал "Та хуримлах гэж байгаа бүсгүй шиг хөөрхөн байна" гэж зүйрлэн хэлбэл сонсогчдын төсөөлж буй эмэгтэй нь сүйт бүсгүй шиг гоо сайхан, сэтгэл догдолсон байдалтай, итгэл найдвар дүүрэн байгаа мэтээр сэтгэлд нь буух болно. Дараах зүйлийг дүрслээд бод. Жишээ нь:

"Толгойгоо цавчуулсан тахиа шиг чи эргэн тойрон гүйх юм". Аль эсвэл "Чи хатгах гэж байгаа могой шиг цагираглаад суух юм" гэх мэт.

Зүйрлэл үг бол тодорхой дүрийн зохих хэмжээний тодотгол болдог. Тухайлбал "гадаа халуун байна" гэж хэлбэл чухам хэр халуун гэдгийг мэдэхийн аргагүй билээ. Харин "үдийн наранд халсан төмөр дээвэр шиг халуун байна" гэж хэлэхэд яг ямар байхыг бид тэр даруй дүрсэлж авна.

Энэ оны наймдугаар сард ХБНГУ-ын Олон нийтийн радио телевиз Дойче Веллегийн сургалтын академиас ирсэн Торстон Карг, Людгер Шадомски, Марк Зайдель зэрэг мэргэжилтнүүд радио сэтгүүл зүйн хичээл заалаа. Тэд лекц, мэтгэлцээн, дүрслэх ур чадвар хөгжүүлэх дасгал, хэлэлцүүлэг, бүлгээр гүйцэтгэх ажил, дууны эвлүүлэг зэргийг 14 хоногт дадлага давамгайлсан сургалтаар заасан нь оролцогчдын эрэлт хэрэгцээнд нийцэж байлаа.

Дүрслэн зурах бас нэг арга бол адилтгал юм. Адилтгал гэдэг нь мөн л аль нэгэн зүйлийн харьцуулалт. Гэхдээ ихэнх зүйрлэл үгийг бодоход адилтгал нь арай үгчилсэн байдаг. Тухайлбал хүний үр боловсрохыг тайлбарлахдаа орон нутагт ургадаг вандуй хатах үедээ үр идээ цацдагтай ижилсүүлсэн нь адилтгалын түгээмэл нэг жишээ юм.

Африк тивд нүүдлийн театрын жүжигчид хүний биед суулгац өвчний үзүүлэх аюултай нөлөөг тайлбарлахын

тулд нойтон поролоныг базаж хуурай болгосныг жишээ болгон харуулжээ. Америкийн телевизээр мансууруулах бодисын эсрэг нэвтрүүлэг явуулахдаа өндгийг тосонд шарах жишээн дээр хүний тархинд мансууруулагч бодис ямар нөлөө үзүүлдгийг тайлбарлаж байна.

Дэлхий нийтэд сурвалжлагын нэр хүнд өсч байна. Сурвалжлагч өөрөө үйл явдлын гэрч, эх сурвалж болдог болохоор ч сурвалжлага гэдэг үг гарсан байх. Гэтэл энэ сайхан төрөл монголын сэтгүүл зүйгээс арчигдахад хүрээд байна. Харснаа оновчтойхон хэлчихэж чаддаггүй бэлэнчлэх дуртай залхуу хүмүүс сурвалжлагын генийг устгаж байна. Үүний шалтгаан доорхи хэдэн хүчин зүйлээс шалтгаалж байна. Энэ нь:

- Халуун цэг үрүү очиж шууд нэвтрүүлэг бэлтгэдэг радио сэтгүүлчид илт ховордож байна. Монголын радиогийн сэтгүүлч Д.Пэлдэнгийн амьд сурвалжлага (тэр үед бүхнийг микрофоноор бичнэ гэж ярьдаг байлаа), хөрөг, Одхүүгийн 1981 онд Байконурын сансрын буудлаас хийсэн шууд нэвтрүүлэг үгүйлэгдэж байна. Энэ төрлийг хөгжүүлэх талаар радио редакциуд бодлого чиглэлтэй хандах хэрэгтэй. Бидний ажиллаж байх ная ерээд оны үед богино хэлбэрийн сурвалжлагын уралдаан тэмцээн их болдог байлаа. Одоо тэр хаачив аа?

- Хялбарчлах дуртай сэтгүүлч олон болжээ. Болж өгвөл өрөөндөө сууж

байгаад утас, эсвэл интернетээр мэдээ бэлтгэдэг дандаа хоёр гуравдугаар эх сурвалжийг ашигладаг ХМХ их байна.

- Хүүхэд залуусын уран сайхны болон дүрслэх сэтгэлгээг хөгжүүлэх талаар БСШУЯ, ерөнхий болон их дээд сургуулиуд анхаарах шаардлагатай байна. Энд гоо сайхны хүмүүжил олгох төрийн бодлого ч хэрэгтэй байна.

Ишлэл

1 "Алтан хараацай" өгүүллэг. Д.Батбаяр www.olloo.mn сайт.

2 А м а р з а я а Л. Радио нэвтрүүлэг дэх дүрслэлийн үр нөлөө. МУИС-ийн "Сэтгүүл зүй" ЭШБ, 2003, № 206 /18/, 63 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. "Алтан хараацай" өгүүллэг. Д.Батбаяр www.olloo.mn сайт.

2. Монголын радиогийн "Хурд" агентлагийн мэдээллийн хөтөлбөрүүд 2006 оны 4, 10 дугаар сарын өглөө, өдөр оройн нэвтрүүлэг.

3. 2005. Радио сэтгүүл зүйн удиртгал. Бэлтгэсэн Д.Батжаргал. Хэвлэлийн хүрээлэн.

4. А м а р з а я а Л. Радио нэвтрүүлэг дэх дүрслэлийн үр нөлөө. МУИС-ийн "Сэтгүүл зүй" ЭШБ, 2003, № 206 /18/.

5. Улаанбаатар хотын радио сонсогчдын судалгааны тайлан. Хэвлэлийн хүрээлэн. Хэрэглэгчдийн судалгааны хамтарсан зөвлөл, 2005 оны 6 дугаар сар.